

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-5

<i>1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>3</i>
<i>2. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороод боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>4-5</i>

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын
04 дүгээр сарын 19-ний өдөр /Баасан гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 34 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 29 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Б.Бейсен, Г.Ганболд, Т.Энхтүвшин;
Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Ж.Батсуурь, С.Ганбаатар, Н.Ганибал,
Г.Дамдинням, Б.Жавхлан, Ц.Туваан, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд.

**Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар
2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Хөрс, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн
байнгын хороод боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн,

мөн яамны Хөрс, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан тусгайлсан саналыг Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 14
77.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 14 минут үргэлжилж, 34 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 55.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА
Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 29 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны хамтран хуралдах хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг та бүхэнд танилцуулъя. Одонтуяа гишүүн, Саранчимэг гишүүн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн, Идэрбат гишүүн, Өнөрболор гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Цэрэнпунцаг гишүүн, Пүрэвдорж гишүүн, Чойжилсүрэн гишүүн, Баделхан гишүүн, Болорчулуун гишүүн, Даваасүрэн гишүүн, Мөнхцэцэг, Г.Мөнхцэцэг гишүүн, Батжаргал гишүүн, Булгантуяа гишүүн, Наранбаатар гишүүн, Сандаг-Очир гишүүд нар хүрэлцэн ирснээр 2 Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, хуралдааны ирц бүрдсэн тул 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. дүгээр асуудал Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл, эцсийн хэлэлцүүлэг байгаа. 2 дахь асуудал “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 2 Байнгын хорооны санаачилсан асуудал байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Амарбаясгалан дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Болорчулуун, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Мөнхцэрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Билгүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөрс, үр сортын хэлтсийн дарга Оюунсүвд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Цолмонжаргал, Үндэсний итгэмжлэлийн төвийн дарга Ням-Эрдэнэ, Үндэсний итгэмжлэлийн төвийн Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Дамдинжав гэсэн бүрэлдэхүүнтэйгээр хүрэлцэн ирсэн байна.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган, хэлтсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болоод хуулийн төслүүдийг та бүхэнд бэлтгэн тараасан байгаад байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулъя. Наранбаатар гишүүнээр танилцуулъя.

Ингээд хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

14.32 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсэг ажиллаж байна уу, дараагийн тогтоол дээр. Сая хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг бол цохичихсон. Болорчулуун сайд санал гаргана гээд байгаа нь тогтоолын төсөл дээр гэж би ойлгож байгаа. Сая хууль бол цохисон шүү дээ, тийм ээ.

Хоёр. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороод боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хууль баталсантай холбогдуулаад авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэллээ. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны санаачилсан төсөл байгаад байгаа. Та бүхэнд 2 Байнгын хорооноос боловсруулсан тогтоолын төслийг тараасан болно.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Тогтоолын төсөл. Ажлын хэсэг. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад ажлын хэсэг тогтоолын төслийн талаарх танилцуулгыг, тогтоолын төслийг уншаад танилцуулчихъя. Монгол Улсын Их Хурал хууль баталсантай холбогдуулаад авах зарим арга хэмжээний тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль баталсантай

холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, газарт даалгасугай.

1.Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга, Худалдааны тухай болон Демпингийн эсрэг хуулийн төслийг тус тус боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, гурилын үнийн зохистой түвшнийг хадгалах зорилгоор Хүнсний тухай хуульд заасны дагуу гурилын эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан импортлох гурилын нэр төрөл, тоо хэмжээг жил бүр тогтоох.

3.Хөдөө аж ахуйн биржээр үрийн болон хүнсний улаан буудайг арилжих талаар судалж шийдвэрлэх.

4.Хүнс, хөдөө аж ахуйн корпорац төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн элеваторийг тариалан эрхлэгчдэд ашиглах боломжийг бүрдүүлэх.

5.Хүнсний улаан буудай стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор жил бүр 100 мянган тонн хүртэлх улаан буудайг улсын нөөцөд худалдан авах.

6.Дотоодын хэрэгцээг хангаад, илүү гарсан хүнсний улаан буудайг экспортлох боломжийг бүрдүүлэх.

7.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу гурилын болон улаан буудайн стандартыг шинэчлэн боловсруулах.

8.Гурил үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний улаан буудайн чанарыг итгэмжлэгдсэн хараат бус лабораторийн сорилтын үр дүнд үндэслэн баталгаажуулах.

Хоёр.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын

Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон Төсвийн байнгын хороонд даалгасугай.

Гурав.Энэ тогтоолыг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна. Хэн картаа сугалав, гишүүдийг дуудаарай. Ирц бүрдсэн байна. Сая 2 Байнгын хорооноос бэлтгэсэн тогтоолын төслийг уншиж танилцуулсан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. Ингээд горимын санал гаргаж байна.

Зарчмын зөрүүтэй санал гараагүй тул ажлын хэсгийн саналыг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын саналыг гаргаж байна. Ажлын хэсгийн саналын тухай. Санал хураалтыг явуулъя горимын саналаар. Гишүүд анхааралтай байгаарай. Горимын саналыг ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хурааж байна. 77,8 хувиар дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх 2 Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Наранбаатар гишүүн та танилцуулах уу? Тэгье. Наранбаатар гишүүн танилцуулъя. Ингээд тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

14.43 цаг

Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Идэвхтэй оролцсон гишүүд болоод ажлын хэсэгт баярлалаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Д.УЯНГА

